

Хяналт-шинжилгээ, үнэлгээний товъёог

1. Нийтлэг үндэслэл
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго
3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй
4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт
6. Хэлтэс, агентлаг тус бүрийн гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын зөвлөмж

**Аймгийн Засаг даргын хэлтэс, агентлагийн дарга
нартай байгуулсан гэрээний биелэлтэнд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн
ажлын танилцуулга**

Нутгийн удирдлагын ордон

2017.10.10

Нэг. Нийтлэг үндэслэл

2017 онд аймгийн Засаг дарга 29 хэлтэс, агентлагийн даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 09 сарын 9-ний өдрийн А/53 дугаар тушаалаар хэлтэс агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээний биелэлт, сумдын Засаг дарга нарын “Төрийн зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралаар хэлэлцүүлэх ажлын хэсгийг томилосон .

Ажлын хэсэг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гэрээний биелэлтийн явцад үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

2017 онд аймгийн Засаг даргатай хэлтэс, агентлагийн дарга нарын байгуулсан үр дүнгийн гэрээний явцад хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид гэрээнд заагдсан зорилт бүрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, шийдвэр гаргагчдад мэдээлэл өгөхөд оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2017 оны 6-р сарын 23-ний өдрийн А/274 дүгээр захирамж болон холбогдох хууль тогтоомжуудын дагуу гэрээний хэрэгжилтэд явцын үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2017 онд аймгийн Засаг даргатай нийт 29 хэлтэс, агентлаг гэрээ байгуулж 25 байгууллага гэрээний биелэлт ирүүлсэн.

Гэрээний хэрэгжилт аймгийн дүнгээр **52,9 хувь** буюу Засгийн газрын 89 дүгээр тогтоолын үнэлгээгээр хэлтэс, агентлагийн даргын үр дүнгийн гэрээний биелэлт хэрэгжих шатандаа байна. Иймд цаашид гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах шаардлагатай.


Үр дүнгийн гэрээний биелэлт **хэрэгжих шатандаа /50-89%/ 21 хэлтэс агентлаг** буюу Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Онцгой байдлын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлэг, Номын сан, Тосонцэнгэл болон Түдэвтэй сум дахь Сум дундын ойн анги, Хүмүүний амьдрах ухааны төв, **хэрэгжилт хангалтгүй /10-49%/ 4 хэлтэс, агентлаг** буюу Аймгийн Музей, Хөгжимт жүжгийн театр, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар болно.

Биеийн тамир, спортын газар, Статистикийн хэлтэс, Автотээврийн үндэсний төвийн Завхан салбар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс гэрээний хэрэгжилт илүүлээгүй учраас үр дүнгийг гэрээг **хэрэгжээгүй /0-9%/** гэж үзэж байна.

Үр дүнгийн гэрээ нь **бүрэн хэрэгжсэн /90-100%/** хэлтэс, агентлаг байхгүй болно.

Хэлтэс, агентлаг, байгууллагуудын үр дүнгийн гэрээнд нийт 1809 зорилт арга хэмжээ тусгагдсанаас 37% нь хэрэгжих шатандаа, 28% нь бүрэн хэрэгжсэн, 16% нь хэрэгжилт хангалтгүй, 17% нь хэрэгжээгүй, 2% нь хэрэгжилт, үр дүнг тооцох хугацаа болоогүй байна.

Мөн хэрэгжилт хангалтгүй 16% буюу 296 арга хэмжээний 24,5% нь хөрөнгийн эх үүсвэр дутагдалтай, 75,5% нь зохион байгуулалтын арга хэмжээнээс шалтгаалсан байна.



Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 134 дүгээр тогтоолын 3.1 дэхь заалтад байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байнагэж заасан байдаг. Гэтэл Боловсрол соёл, урлагийн газар болон Хөгжимт жүжгийн театр, Аймгийн Музей нь байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт ирүүлээгүй тул үр дүнгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх үндэслэл болсон.

Мөн Эрүүл мэндийн газар манлайллын зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй бөгөөд жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 23 арга хэмжээний /26% нь хөрөнгийн эх үүсвэргүй, 74% нь хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтээ хангаагүй, зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй/ хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлж байна.

Үр дүнгийн гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүнд тусгагдсан удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төрийн байгууллагын ажлын уялдаа холбоог хангах зорилтын хэрэгжилтийг хангуулах шалгуур үзүүлэлтийн нэг болох байгууллагын дарга нарын шуурхай хуралдааний ирцийн бүртгэлтийг биелэлтийг тооцоход 2017 оны эхний 9 сарын байдлаар 35 удаа хуралдсан бөгөөд 30 удаа хуралдаа суусан буюу 85%-ийн ирцтэй байгууллага 2 /Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Гэр, бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар/, 5 удаа хуралдаа суусан буюу 14,3%-ийн ирцтэй байгууллага 1 /Автотээврийн үндэсний төвийн Завхан аймаг дахь салбар/ байна

**ХЭЛТЭС, АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРЫН ҮР ДҮНГИЙН
ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**
/ эхний 9 сарын байдлаар/

№	Хэлтэс, агентлагийн нэрс	Нийт арга хэмжээний тоо	Хугацаа болоогүй арга хэмжээний тоо	Үнэлгээ				Нэгдсэн	
				100	70	30	0	хувь	үнэлгээ
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	86	3	9	39	25	10	57.9	2.9
2	Биеийн тамир, спортын газар	Биелэлт ирүүлээгүй						0	0.0
3	Боловсрол, соёл, урлагийн газар	137	0	23	17	14	83	47.1	2.4
4	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	60	2	6	28	23	1	58.2	2.9
5	Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар	125	2	43	35	26	19	73.7	3.7
6	Мэргэжлийн хяналтын газар	68	0	14	37	14	0	66.5	3.3
7	Онцгой байдлын газар	64	3	16	34	10	1	69.2	3.5
8	Орон нутгийн өмчийн газар	57	4	9	29	13	2	58.4	2.9
9	Санхүүгийн хяналт, аудитын алба	29	1	12	4	4	8	67.4	3.4
10	Стандарт, хэмжилзүйн хэлтэс	39	0	5	28	4	2	62.2	3.1
11	Статистикийн хэлтэс	Биелэлт ирүүлээгүй						0	0.0
12	Татварын хэлтэс	40	0	10	19	10	1	64.2	3.2
13	Улсын бүртгэлийн хэлтэс	42	1	23	15	3	0	76.5	3.8
14	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	140	0	101	34	2	3	87.3	4.4
15	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	56	0	6	41	8	1	68.4	3.4
16	Хүнс, хөдөө аж ахуйн газар	85	7	24	33	16	5	66.4	3.3

17	Цагдаагийн газар	42	0	6	30	3	3	68.4	3.4
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	39	1	14	18	2	4	72.5	3.6
19	Шүүхийн шинжилгээний алба	62	0	41	14	5	2	79.4	4.0
20	Эрүүл мэндийн газар	182	5	27	74	45	31	48.1	2.4
21	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	Биелэлт ирүүлээгүй						0	0.0
22	Номын сан	71	3	30	9	5	24	55.5	2.8
23	Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн анги	30		9	12	7	2	51.4	2.6
24	Түдэвтэй сум дахь Сум дундын ойн анги	44	3	3	19	19		54.7	2.7
25	Нэгдсэн эмнэлэг	151	0	55	65	20	11	61.2	3.1
26	Хөгжимт жүжгийн театр	55	0	1	6	6	41	23.4	1.2
27	Аймгийн музей	70	1	5	5	7	52	33	1.7
28	Хүмүүний амьдрах ухааны төв	35	0	11	15	5	2	63.8	3.2
29	Автотээврийн үндэсний төвийн Завхан салбар	Биелэлт ирүүлээгүй						0	0.0
	Нийт	1809	36	503	660	296	308	52.9	2.6





Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

1. Үр дүнгийн гэрээний биелэлт аймгийн хэмжээнд 52,9%-тай буюу хэрэгжих шатандаа байгаа учраас хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр зөвлөмж чиглэл, үүрэг даалгавар хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавих шаардлагатай байна.
2. Хэлтэс агентлагийн дарга нар үр дүнгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй ажлуудыг хяналтандаа авч, биелэлтийг эрчимжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах
3. Цаашид үр дүнгийн гэрээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, хөтөлбөр, дэд хөтөлбөр, суурь судалгаанд үндэслэн төсөв санхүүд тулгуурлан, цаг хугацааг тооцон, бодитой хүрэх үр дүнтэй үр өгөөжтэй асуудлуудыг тусгуулах

4. Хэлтэс, агентлагын дарга нар үр дүнгийн гэрээний явцын хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 6.3 дахь үнэлгээний аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх
5. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулж тайлагнах
6. Тасарсан болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг баримтаар нотолж тайлагнах
7. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх
8. Арга хэмжээг тодорхой төлөвлөгөөнд заасан хугацаандаа хэрэгжүүлэх
9. Төрийн үйлчилгээний байгууллагууд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу гэрээ байгуулах
10. Манлайлал болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтыг төлөвлөхдөө 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын баримтлах
11. Үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг 2 удаа хангалтгүй биелүүлсэн Биеийн тамир спортын газар, Статистикийн хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэсүүдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авах

Зургаа. Хэлтэс, агентлаг тус бүрийн гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын зөвлөмж

5.1. Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 137 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 65 ажил арга хэмжээ 56,1 %, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 4 ажил арга хэмжээ 85 %, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 68 ажил арга хэмжээ 0 %, нийт гэрээний хэрэгжилт 47,1% буюу хэрэгжилт хангалтгүй байна.

1. Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3.1-д “Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө нь энэхүү гэрээний нэг салшгүй хэсэг байна.....” гэж заасан, төлөвлөгөөний хэрэгжилт тооцоогүй,

2. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцохдоо хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхой тайлагнах

3.Манлайллын зорилтын 4е, 4ё, 4ж-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг буруу тайлагнасан,

4.Манлайллын зорилтод нийт захиалгат бүтээгдэхүүнд тусгавал зохих арга хэмжээнүүдийг тусгасан,

5.Дэд хөтөлбөр, болон бодлогын баримт бичгүүдийн төслийг боловсруулж, АЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 10 сард багтаан аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн хурлаар оруулах

5.2 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 4 бүлэг зорилтын хүрээнд 125 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 28 ажил арга хэмжээ 59,2%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 9 ажил арга хэмжээ 94%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 88 ажил арга хэмжээ 67,7%, нийт гэрээний хэрэгжилт 73,7 % буюу хэрэгжих шатандаа байна.

1.Манлайллын зорилт 4а, 4в, 4д, нийт захиалгат арга хэмжээний 1.7, 1.15, 2.4, 2.5, 2.11, 3.5, 3.6, 3.7, 3.12, 3.13, 3.15, 4.1, 4.11, 5.3 дахь арга хэмжээнүүд дотоод хүчин зүйлсээс шалтгаалан тасарсан бөгөөд хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа, бэлтгэл ажил болон хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байна. Иймд дээрх ажлуудыг эрчимжүүлэх

2.Тусгай захиалгат бүтээгдэхүүний арга хэмжээг нийт захиалгат бүтээгдэхүүнд оруулан тайлагнасан.

3.Гэрээнд нэг үр дүнд хүрэх, нэг зорилго чиглэлийн зорилт арга хэмжээг нарийвчлан жижиглэн тусгасан нь хэрэгжилтийн утга агуулга давхардах нөхцөлийг үүсгэсэн

4.Батлагдаагүй үндэсний хөтөлбөр, журмыг гэрээнд тусгасан,

5.Зорилтыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ гэрээнд тусгагдсаны дагуу заавар, дүрэм журам, удирдамжийг боловсруулж, батлуулалгүй ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн

Цаашид:

1.Сумын Засаг даргын Тамгын газарт гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын асуудал хариуцахад тохиромжтой орон тоог судалж, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулах

5.3.Аймгийн Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сангийн эрхлэгчийн 2017 оны үр дүнгийн гэрээнд 1 бүлэг зорилтын хүрээнд 71 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 71 ажил арга хэмжээ 55,6 % буюу хэрэгжилт хангалтгүй байна.

1.Зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулах, мэдээлэл хангалтгүй, тооцоо судалгаа, үр дүнг тооцоогүй,

2.Зорилт 1.3, 1.6, 1.8, 2.5, 5.8, 5.11, 5.17, 5.18, 5.19, 6.1, 6.3, 6.6, 7.2, 7.5, 7.6 дахь арга хэмжээнүүд хугацаа хоцорч, тасарсан бөгөөд хугацаа болоогүй гэж буруу тайлагнасан,

3.Зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлт хэмжигдэхүйц, арга хэмжээний үр дүнг тооцож болохуйц тодорхойлох

Цаашид:

1.Байгууллагын үйл ажиллагааны талаар үнэлгээ, эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах

2.Тасарсан болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг баримтаар нотолж тайлагнах

3.Аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу байгуулах

4.Гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу тайлагнах, байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ буюу дотоод ажил хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулах сургалтанд хамруулах

5.4.Аймгийн Орон нутагт судлах музей захирлын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 70 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 19 ажил арга хэмжээ 39 %, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 5 ажил арга хэмжээ 50%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 46 ажил арга хэмжээ 0%, нийт гэрээний хэрэгжилт 33,0 % буюу хэрэгжилт хангалтгүй байна.

1.Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3.1-д “Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө нь энэхүү гэрээний нэг салшгүй хэсэг байна.....” гэж заасан, төлөвлөгөөний хэрэгжилт тооцоогүй,

2.Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан мэдээ мэдээлэл хангалтгүй, зарим арга хэмжээний биелэлтийг тооцоогүй орхигдуулсан, утга найруулгын алдаатай,

3.Албан бичиг хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөөгүй

4.Зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулах, мэдээлэл хангалтгүй, тооцоо судалгаа, үр дүнг тооцоогүй,

5.Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгавал зохих зорилт, арга хэмжээг манлайлал, мэдлэг чадварын зорилт арга хэмжээнд тусгасан

Цаашид:

1.Аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу байгуулах

2.Гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу тайлагнах, байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ буюу дотоод ажил хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулах сургалтанд хамруулах

3.“Байгууллага сурталчилах” жил болгон заралсан шийдвэр, зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг тодорхой болгох

5.5.Аймгийн Музейн захирлын 2017 оны үр дүнгийн гэрээнд менежерийн эрх үүрэг бүлэгт 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ тусгагдаж хэрэгжилт 46,9 %, нийт захиалгат бүтээгдэхүүний 36 арга хэмжээ 0 % гэрээний нийт хэрэгжилт 23,4 % буюу хэрэгжилт хангалтгүй байна.

1.Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3.1-д “Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө нь энэхүү гэрээний нэг салшгүй хэсэг байна.....” гэж заасан, төлөвлөгөөний хэрэгжилт тооцоогүй,

2.Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан мэдээ мэдээлэл хангалтгүй, зарим арга хэмжээний биелэлтийг тооцоогүй орхигдуулсан, утга найруулгын алдаатай,

3.Зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулаагүй, мэдээлэл хангалтгүй, тооцоо судалгаа, үр дүнг тооцоогүй,

Цаашид:

1.Соёл, урлагийн байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

2.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх

3.Аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу байгуулах

4.Гэрээний хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу тайлагнах, байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээ буюу дотоод ажил хариуцсан мэргэжилтэнг чадавхжуулах сургалтанд хамруулах

5.6.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 56 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 6 ажил арга хэмжээ 66%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 4 ажил арга хэмжээ 30%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 35 ажил арга хэмжээ 67,7%, тусгай захиалгат бүтээгдэхүүний 11 арга хэмжээ 70%, нийт гэрээний хэрэгжилт 58,4 % буюу хэрэгжих шатандаа байна.

1.Зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулах,

Цаашид

1.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх.

2.Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн хурлыг тогтмолжуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төсөл хөтөлбөрийн явцын тайланг 2017 оны 10 дугаар сард багтаан хэлэлцүүлэх

3.Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамжийн сангийн төсвийн хуваарилалт, зарцуулалтанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг эрчимжүүлж, дүнг мэдээллэх

4.Ажилд зуучлах үйлчилгээний явц эхний 9 сарын байдлаар 43 хувийн хэрэгжилттэй байна. Иймд тухайн үйлчилгээний явцын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, цаашид хэрэгжилтийн хувийг хангахад чиглэсэн ажил арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах

5.Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулахдаа Хүн амын хөгжил нийгмийн хамгаалын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/32 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах

6.Хүний нөөцийн ил, тод нээлттэй байдлыг хангах зорилтын хэрэгжилтийг сайжруулж, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.5 дахь заалтуудыг мөрдөн, хэрэгжилтийг хангах

5.7.Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 56 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 11 ажил арга хэмжээ 23,6%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 3 ажил арга хэмжээ 70%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 162 ажил арга хэмжээ 50,9%, нийт гэрээний хэрэгжилт 48,1 % буюу хэрэгжилт хангалтгүй байна.

1.Манлайллын зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилтийг гаргаагүй

2.Тусгай захиалгат бүтээгдэхүүний арга хэмжээг нийт захиалгат бүтээгдэхүүнд оруулан тайлагнасан.

Цаашид:

1.Гэрээний 1.4.2, 1.4.3, 1.4.4 дэх арга хэмжээнүүдийг дараа оны гэрээнд тусгах тохиолдолд нэгтгэх

2.Зорилт, арга хэмжээний хүрэх түвшин,шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц, үр дүнг тооцож болохуйцаар томъёолох

3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын салбар зөвлөл, Халдварын сэргийлэлт хяналтын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, зөвлөлийн зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөөг боловсруулан ажиллах

4.Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг өргөжүүлэх, Эрүүл мэндийн байгууллагуудтай зайн хурал, сургалт хийж хэвших үйл ажиллагааг тогтмолжуулах, Эрүүл мэндийн салбарт улс хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хэрэгжилтийг ханган, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд улсын ба хувийн салбарын зохистой бүрдэл бий болгох зорилтуудын хэрэгжилтийг хангах төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулах

5.8.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 151 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 18 ажил арга хэмжээ 57.1%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 3 ажил арга хэмжээ 56.7%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 130 ажил арга хэмжээ 69,8%, нийт гэрээний хэрэгжилт 61.2 % буюу хэрэгжих шатандаа байна

1.Тусгай захиалгат бүтээгдэхүүний арга хэмжээг нийт захиалгат бүтээгдэхүүнд оруулан тайлагнасан.

Цаашид:

1.Лаборторын тоног төхөөрөмжийг дотоод сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлэх

2.Байгууллагын эрдэм шинжилгээний судалгааны багийг байгуулж, ажиллах журам боловсруулахад бодлогын хэлтэс, газраас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч ажлыг эрчимжүүлэх

3.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Завхан аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөө батлан хэрэгжилтийг хангаж ажиллах

5.9.Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 86 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 62%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 2 ажил арга хэмжээ 70%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 79 ажил арга хэмжээ 56,3%, нийт гэрээний хэрэгжилт 57,9 % -тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг эрчимтэй зохион байгуулах

2.Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах

3.Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах

4.Аймгийн байгаль орчны салбарын зөвлөгөөнийг зохион байгуулах

Биологийн олон янз байдлын дэд хөтөлбөр боловсруулж, батлуулах, Отгонтэнгэр, Зарт, Улаан хаалга, Цэцүүх, Баянзүрхийн рашааны гидрогеологийн судалгааны ажлын үндэслэлийг боловсруулж, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх /Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээнээс хасагдаагүй/

5.Аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэл хийж, ашиглалтыг сайжруулах талаар ажил зохион байгуулах /Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээнээс хасагдаагүй/,

6.Аймгийн төвийн үерийн хамгаалалтын далангийн бүрэн бүтэн байдал, өргөтгөлийн үйл ажиллагааг хянан үзэх /Аймгийн Засаг даргын сайдтай байгуулсан гэрээнээс хасагдаагүй/,

7.Дөрвөлжин сум Баянайраг эксплорэйшн ХХК-тай байгуулах хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тусгуулах саналаа хүргүүлэх,

8.Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг УЦУОШГ-тай хамтарн зохион байгуулах

9.Сумдын хогийн төвлөрсөн цэгүүдэд ландфилл байгуулах аргачлалыг хүргүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

10.Аймгийн аялал жуулчлалын мэдээллийн санг үүсгэх

11.Байгууллагын архивыг цахим программд шилжүүлэх

5.10.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 60 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 74%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 4 ажил арга хэмжээ 66,6%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 51 ажил арга хэмжээ 53,4%, нийт гэрээний хэрэгжилт 58,2 % -тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

1.Алдархаан сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулж дуусах

2.Тосонцэнгэл, Дөрвөлжин сумдын газар зохион байгуулалтын болон нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсуулж дуусгах

3.Газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа эрхийн зөрчилтэй газрын зөрчлийг арилгах арга хэмжээг эрчимжүүлэх

4.Кадастрын бүртгэлийн баримтыг зориулалтын байр болон өрөө тасалгаанд хадгалах, хамгаалалтыг сайжруулах

5.Улиастай хотын цэвэр усны лабораторийг тоног төхөөрөмжөөр хангах ажлыг эрчимжүүлэх

6.Сум, суурин газрын дулаан хангамжийг сайжруулах хөтөлбөр боловсруулах судалгаа хийх ажлыг хэрэгжүүлэх

5.11.Стандарт, хэмжилзүйн хэлтэсийн даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 39 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 11 ажил арга хэмжээ 69%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 5 ажил арга хэмжээ 70%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 23 ажил арга хэмжээ 57,3%, нийт гэрээний хэрэгжилт 62,2 % -тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

1.Стандарттай Завхан дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг эрчимжүүлэх

2.Улсын баталгаажуулалтанд заавал хамруулах хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулалтанд бүрэн хамруулах ажлыг эрчимжүүлэх

3.Байгууллагынхаа үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны үр дүнгээр үйл ажиллагаагаа сайжруулах, иргэдэд хүртээмжтэй үйлчлэх

4.Үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай цахилгаан жин, хүнсний мерник, хийн шатахуун түгээгүүр шалгах болон эмнэлгийн даралтын аппарат баталгаажуулах эталон төхөөрөмжтэй болох

5.Хүнсний зах дэлгүүр, шатахуун станцуудад хэрэглэж байгаа жин хэмжүүрүүдэд байнгын хяналт тавьж, үр дүнг хэрэглэгчдэд өргөнөөр суртчилах

5.12.Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлт хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 140 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 76%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 3 ажил арга хэмжээ 80%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 132 ажил арга хэмжээ 88%, нийт гэрээний хэрэгжилт 87,3 % буюу хэрэгжих шатандаа байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

1.Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа гүний худгийг төрийн өмчийн бүртгэлд хамруулж өөрийн эзэмшилд авах ажлыг эрчимжүүлэх

2.Өртөөдийн дарга нарын сургалтыг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх

5.13.Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлт 66,4 буюу хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 85 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 100%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 4 ажил арга хэмжээ 47,5%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 76 ажил арга хэмжээ 63,9%, нийт гэрээний хэрэгжилт 66,4 % -тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

- 1.Сайн малчин дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэх
- 2.Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах
- 3.Завхан буурал үүлдрийн ямааны 5-10 жилийн хугацаанд явуулах үржлийн ажлын бүдүүвч, төлөвлөгөөг гаргаж баталгаажуулах
- 4.Бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, доройтсон газрыг нөхөн сэргээх бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах
- 5.Жимс, жимсгэнэ дэд хөтөлбөр боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлэх
- 6.Аймгийн ургацын баяр-2017 арга хэмжээг зохион байгуулах
- 7.Хөнгөлөлттэй зээлээр олгосон бага оврын трактор, техник тоног төхөөрөмжийн эргэн төлөлтийг сайжруулах ажлыг зохион байгуулах
- 8.Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг сурталчлах, хамруулах ажлыг эрчимжүүлэх

5.14.Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн даргийн үр дүнгийн гэрээний биелэлт хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 30 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 38%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 0 ажил арга хэмжээ 0%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 25 ажил арга хэмжээ 73%, нийт гэрээний хэрэгжилт 51,4%-тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

- 1.Ойн тухай хуулийн сурталчлах ажлыг эрчимжүүлэх, харъяа сумддаа ажиллах
- 2.Хариуцсан сумдын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг эрчимжүүлэх
- 3.Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг үр дүнтэй зохион байгуулах

5.15.Түдэвтэй сум дахь Сум дундын ойн ангийн даргын үр дүнгийн гэрээний биелэлт хэрэгжих шатандаа буюу 3 бүлэг зорилтын хүрээнд 86 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайллын зорилтын 5 ажил арга хэмжээ 54%, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 2 ажил арга хэмжээ 70%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 37 ажил арга хэмжээ 51,8%, нийт гэрээний хэрэгжилт 54,7 %-тай байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Ойн тухай хуулийн сурталчлах ажлыг эрчимжүүлэх, харъяа сумддаа ажиллах

Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг үр дүнтэй зохион байгуулах

2.Хариуцсан сумдын ойн менежментийн төлөвлөгөөг бололвсуурах ажлыг эрчимжүүлэх

5.16.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Шинээр томилогдсон албан хаагчдыг гэр орон ахуй нөхцөлөөр хангахад анхаарч ажиллах

2.Хорих ангийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлэн, орон нутгийн бүтээн байгуулалт, үйлвэрлэлийн арга хэмжээнд ялтнуудыг татан оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авч, бусдад учруулсан гэм хорын хохирлоо төлөх, ар гэртээ тус нэмэр болох, ажил мэргэжлийн дадал, ур чадвар, чадамж эзэмшүүлэн төлөвшүүлэхэд хамтын ажиллагааг эрчимжүүлэх.

3.Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг эрчимтэй зохион байгуулах

4.Байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулах

5.17.Шүүхийн шинжилгээний албаны даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа нийт 62 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

1.Туулах чадвар сайтай, цогцос зөөвөрлөх зориулалтын автомашиныг шийдвэрлүүлэх шаардлагатай

2.Албан хаагчдыг албан орон сууцаар хангах асуудлыг анхаарч ажиллах

3.Алдархаан сумын газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулж дуусах

5.18.Улсын бүртгэлийн хэлтсийн даргын үр дүнгийн гэрээ хэрэгжих шатандаа байна. Үүнд:

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

1.Хэлтсийн төрөлжсөн архивуудын үйл ажиллагааны хангамжийг сайжруулах шаардлагатай.

2.Гадаад паспортын үйлчилгээг сайжруулах

3.Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг үр дүнтэй зохион байгуулах

4.Сумдын улсын бүртгэгчдийн гурвалсан гэрээний биелэлтийг нарийвчилан гаргаж, биелэлтийг тооцох

5.19.Цагдаагийн газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлт хэрэгжих шатандаа байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарыг мэдээллийн сүлжээнд бүрэн холбоход анхаарч ажиллах

2.Цагдаагийн алба хаагчийн ажиллах амьдрах нөхцлийг сайжруулахад анхаарах

3.Олон нийтийн цагдаагийн ажилтанг ажиллуулах

4.Орон нутгийн замд хяналтын постыг шинээр нэмж байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулах талаар анхаарах

5.20.Санхүүгийн хяналт аудитын албаны даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 29 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайлал, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд 11 ажил арга хэмжээ 76,6 %, Тусгай захиалгат ажил 6 ажил арга хэмжээ 38,3 %, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 23 ажил арга хэмжээ 59,1 %, нийт гэрээний хэрэгжилт 67,4% хэрэгжилттэй байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд хангалтгүй байгаа арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах

2.Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах

3.Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх

4.Дэвшүүлсэн зорилтын хүрээнд ажлын байрны болон тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах арга хэмжээг авч ажиллах

5.21.Онцгой байдлын газар даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 53 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайлал, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд 12 ажил арга хэмжээ 69 %, Тусгай захиалгат ажил 29 ажил арга хэмжээ 62,4 %, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 25 ажил арга хэмжээ 73,2 %, нийт гэрээний хэрэгжилт 69,2% хэрэгжилттэй байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын дагуу дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангуулах

2.Аймгийн Засаг даргын нөөц сангийн хүрээнд гамшгаас хамгаалх эрсдлийн сан байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журмыг боловсруулан батлуулах

3.Аймгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчлэх

4.Сумдыг гамшгийн үеийн зарлан мэдээлэл холбоо дамжуулах сэрээн дохиотой болгох

5.Засвар үйлчилгээ, тохижилтын чиглэлээр дэвшүүлсэн зорилтыг хангаж ажилах

5.22.Мэргэжлийн хяналтын газрын даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 68 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайлал, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд 14 ажил арга хэмжээ 71,6 %, Тусгай захиалгат ажил 3 ажил арга хэмжээ 56,6 %, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 51 ажил арга хэмжээ 55,1 %, нийт гэрээний хэрэгжилт 66,5% хэрэгжилттэй байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Эрүүл мэнд, боловсрол, соёлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжид хөтөлбөрийн дагуу салбарын сургалтыг зохион байгуулах, зорилтыг хангах

2.Аймгийн нэгдсэн лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр дэвшүүлсэн зорилт арга арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

5.23.Татварын хэлтсийн даргын 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 бүлэг зорилтын хүрээнд 78 ажил арга хэмжээ төлөвлөгдсөн байна.

Үүнээс: Манлайлал, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд 9 ажил арга хэмжээ 69%, Тусгай захиалгат ажил 13 ажил арга хэмжээ 65,3%, нийт захиалгат бүтээгдэхүүн буюу байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөний 79 ажил арга хэмжээ 40%, нийт гэрээний хэрэгжилт 64,2% хэрэгжилттэй байна.

Цаашид гэрээнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

1.Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3.1-д “Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө нь энэхүү гэрээний нэг салшгүй хэсэг байна.....” гэж заасан, төлөвлөгөөний хэрэгжилт тооцоогүй,

2.Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцохдоо хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан , үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхой тайлагнах

Ажлын хэсгийн дарга	Д.Оюунгэрэл	АЗДТГ-ын ХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн
Гишүүд	Н.Ядамцоо	АЗДТГ-ын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн
	У.Батзаяа	АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн
	Б.Энхжаргал	АЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Б.Цэрэнханд	АЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн

